



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/408

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах нэгжид тэмдэг хэрэглэх журам”-ыг нэгдүгээр, тэмдгийн загвар, хэмжээ, өнгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нарт үүрэг болгосугай.


3. Хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (хурандаа Б.Үнэнбаатар), Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх), Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
А/408 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИ, ЭРЭН ХАЙХ АВРАХ НЭГЖИД ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар, бүлэг (цаашид "нэгж" гэх)-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд хөтлөгдөх баримт бичгийг баталгаажуулах тэмдэг (цаашид "тэмдэг" гэх) хийлгэх, хэрэглэх, хадгалахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжид хамаарна.

1.3. Нэгж нь харьяалал, оноосон нэр, хяналтын дугаар, код бүхий тэмдэг хэрэглэнэ.

1.4. Нэгжид тэмдэг хийлгэх, олгох, хүлээлцүүлэх, хадгалах, хураалгах, дахин хийлгэх, ашиглалтад хяналт тавих асуудлыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга хариуцна.

1.5. Анги, салбарын зохион байгуулалтад үүрэг гүйцэтгэдэг салаа, бүлэг тэмдэг хэрэглэхгүй.

Хоёр. Тэмдэг хийлгэх

2.1. Нэгж шинээр болон дахин тэмдэг хийлгэх тохиолдолд тухайн Онцгой байдлын газраас харьяа улсын бүртгэлийн байгууллагад хандан зөвшөөрөл, хяналтын дугаар авч, хийлгэнэ.

2.2. Тэмдэг нь батлагдсан загвар, хэмжээ, өнгөтэй байна.

2.3. Тэмдгийг шинээр болон дахин хийлгэсэн, хураалгасан энэхүү журмын 5.1, 5.2-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид бүртгүүлнэ.

Гурав. Тэмдэг хэрэглэх

3.1. Тэмдгийг нэгжийн дарга, захирагч, мөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдсон албан үүргийг түр орлон гүйцэтгэгч түшнэ.

3.2. Тэмдгийг энэхүү журмын 3.1-т заасан албан тушаалтны баталгаат гарын үсэг зурсан нэгжид хөтлөгдөх баримт бичиг /томилгоот ээлжийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх хуваарь, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, нэгжийн тайлан, дадлага сургалтын төлөвлөгөө/-ийг баталгаажуулахад хэрэглэнэ.

3.3. Тэмдгийг "Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага" MNS 5140-2:2021 стандартад заасны дагуу гарын үсгийн зурагдсан хэсгийг оролцуулан, бүрэн, тод, тэгш дарна.

Дөрөв. Тэмдгийн хадгалалт, хяналт

4.1. Тэмдгийг энэхүү журмын 3.1-т заасан албан тушаалтан ээлжийн амралт авах, томилолтоор ажиллах, эрүүл мэндийн шалтгаан, сургууль, сургалт, хувийн

чөлөөтэй байх зэрэг эзгүй байх хугацаанд төв, орон нутгийн Онцгой байдлын газрын даргын шийдвэрээр нотломж үйлдэн хүлээлцэнэ.

4.2. Тэмдэг хүлээлцүүлсэн бүртгэлийг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан хөтөлнө.

4.3. Тэмдэг хүлээлцэх бүртгэлийг “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын дагуу бүртгэнэ.

4.4. Энэхүү журмын 3.1-т заасан албан тушаалтан нь тэмдгийн хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцах бөгөөд тэмдгийг ажлын байранд, цоожтой шүүгээ, сейфт хадгална.

Тав. Бусад


5.1. Тэмдгийг үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд нэн даруй төв, орон нутгийн Онцгой байдлын газрын даргад мэдэгдэн, цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ.

5.2. Гэмтэлтэй буюу анхны загвараас дардас нь зөрүүтэй тэмдгийг ашиглахыг хориглоно.

5.3. Нэгжид хэвлэмэл хуудас хэрэглэхгүй бөгөөд тэмдгийг энэхүү журмын 3.2-т зааснаас бусад зорилгоор ашиглах, бусдад шилжүүлэх, ажлын байрнаас гадагш авч гарахыг хориглоно.


5.4. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл ногдуулна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
А/408 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нэг. Тэмдгийн загвар, хэмжээ, өнгө

1.1. Загвар, хэмжээ:



Тайлбар: “Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 52 дугаар анги”, “Төв аймгийн Онцгой байдлын газрын Эрдэнэ сум дахь Эрэн хайх, аврах бүлэг” гэж дээрх загварын дагуу дардасны бичээс нь үндэсний бичгээр, дармалаар бичигдсэн байна.

1.2. Тэмдгийн өнгө:

Дардас нь Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 3.8 дахь хэсэгт заасны дагуу MNS 6262:2011 стандартаар тогтоосон Монгол Улсын Төрийн далбааны адил улаан өнгө (С 010%, М 100%, Y 090%, К 000%)-тэй байна.